



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/466

Улаанбаатар хот

**ГБаянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Ажлын албаны данс бүртгэлээс  
тээврийн хэрэгсэл хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 33,125,794.0 /гучин гурван сая нэг зуун хорин таван мянга долоон зуун ерэн дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай соната-7 маркийн 05-01 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /П.Сумъяасүрэн/-нд зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /П.Сумъяасүрэн/-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ